



“СААНТ МАРАЛ ” ЭМНЭЛЭГТ ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭГЧДИЙН МӨРДӨХ ДОТООД ЖУРАМ

1. Хэвтэн эмчлүүлэгчид 12 цагаас өмнө ирж хэвтэнэ. Хэвтэх үедээ зохих бичиг баримтыг болон иргэний үнэмлэх, төлбөр төлсөн баримт, амбулаторийн карт шаардлагатай шинжилгээг бүрдүүлсэн байх Амбулаторийн картыг эмчлэгч эмч авч эмнэлгээс гартал хадгална.
2. Тасгийн эмчилгээ үйлчилгээний болон эргэлт уулзалтын цагийн хуваарийг мөрдөх сахина. Эргэлтийн цаг өглөө 09 цагаас оройн 21 цагийн хооронд байна.
3. Хэвтэн эмчлүүлэгчид тасагт байрлуулсан санамжийг мөрдөж тасгийн эд хөрөнгөнд өөриймсөг хандан ариг гамтай зөв эдэлж хэрэглэнэ.
4. Хэрэв өөрийн буруугаас тасгийн аливаа өмчид гэмтэл эвдрэл учруулсан бол хохирлыг 3 дахин нугалж төлнө .
5. Хувийн эд зүйлс, мөнгө, гар утас, үнэт эдлэлийн хадгалалт хамгаалалтын эмчлүүлэгч өөрөө хариуцна .
6. Эмнэлгийн дотоод журмыг мөрдүүлэх талаар тавьсан эмч, сувилагч, асрагч, жижүүр нарын шаардлагыг хүлээн авч биелүүлнэ .
7. Тасгийн ажилчдын хөдөлмөрийг хүндэлж өрөөний ба хувийн ариун цэвэр болон гарын ариун цэврийг сайтар сахина .
8. Амралтын болон баярын өдрүүдэд эмчийн зөвшөөрлөөр түр гарч болно. Бусад үед чөлөөгөөр гарах шаардлага гарвал эмч болон сувилагчдаа урьдчилан мэдэгдэнэ .
9. Эмнэлгээс гарах өдрөө амбулаторын карт, эмнэлгийн хуудсаа эмч сувилагчаас авна.
10. Тасгийн хэвтэн эмчлүүлэгчдэд дараахи зүйлсийг хориглоно . Үүнд :
 - Тамхи татах
 - Согтууруулах ундаа хэрэглэх , хөзөр тоглох
 - Өвчний түүх үзэх, авч явах
 - Чөлөө авалгүй гадагш гарах
 - Өрөөндөө гаднаас хүн зөвшөөрөлгүй оруулах
 - Өрөөндөө цахилгаан хэрэгсэл дүрдэг плитка хэрэглэх
11. Эмнэлгийн дотоод журам зөрчсөн үйлчлүүлэгчид зохих хууль дүрмийн дагуу сануулах, эмнэлгийн хуудас олгохгүй байх, эмнэлгээс гаргах зэрэг арга хэмжээг хүлээлгэнэ. Өөрийн буруугаас болон өөрийн хүсэлтээр эмнэлгээс гарч буй тохиолдолд эрүүл мэндийн хохирлыг хариуцахгүй бөгөөд төлбөр эргэн олгогдохгүй болно .
12. Эмнэлгийн газраас бусад газар буюу гадуур гарч яваад аливаа асуудалд өртсөн тохиолдолд эмнэлгийн зүгээс хариуцлага хүлээхгүй болно.